

Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2020.07.22-ны өдрийн 06 дугаар хуралдааны шийдвэрээс:

6.1. “Онцгой байдлын байгууллагын алба хаагчид хөдөлмөрийн чадвар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын нэг удаагийн нөхөн олговор олгох журам”-ын төслийг батлуулах тухай хэлэлцээд төслийг Шадар сайдын ажлын албаар дамжуулан ЗГХЭГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв.

6.2. “Алслагдсан аймаг, суманд ажиллаж байгаа Онцгой байдлын байгууллагын алба хаагчид нэмэгдэл олгох журам”-ын төслийг батлуулах тухай хэлэлцээд төслийг Шадар сайдын ажлын албаар дамжуулан ЗГХЭГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв.

6.3. “Онцгой байдлын байгууллагын алба хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам”-ын нэмэлт өөрчлөлтийн төслийг батлуулах тухай хэлэлцээд төслийг Шадар сайдын ажлын албаар дамжуулан ЗГХЭГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв.

6.4. “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн офицер, ахлагчийн болон албаны үнэмлэх олгох, хэрэглэх журам”-ын төслийг батлуулах тухай хэлэлцээд ОБЕГ-ын даргын тушаалаар батлуулахаар шийдвэрлэв.

6.5. “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн мэргэшлийн зэргийн үнэмлэх, тэмдэг олгох журам, үнэмлэхийн загвар, тэмдгийн загвар”-ын төслийг батлуулах тухай хэлэлцээд Шадар сайдын тушаалаар батлуулахаар хүргүүлэхээр шийдвэрлэв.

6.6. “Онцгой байдлын албаны шагналын төрөл, түүнийг олгох журам”, “Онцгой байдлын ерөнхий газрын шагналын төрөл, түүнийг олгох журам”-ын төслийг батлуулах тухай хэлэлцээд Шадар сайдын тушаалаар батлуулахаар хүргүүлэхээр шийдвэрлэв.

6.7. “Онцгой байдлын ерөнхий газар болон салбар, нэгжийн хугацаат тайлан мэдээг тайлагнах, дүгнэх журам”-ын төслийг батлуулах тухай хэлэлцээд холбогдох засвар өөрчлөлтийг тусган ОБЕГ-ын даргын тушаалаар батлуулахаар шийдвэрлэв.

6.8. “Сэтгэл зүй, сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх журам”-ын төслийг батлуулах тухай хэлэлцээд батлав.

6.9. “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”-ын нэмэлт өөрчлөлтийн төслийг батлуулах тухай хэлэлцээд Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр Шадар сайдын ажлын албанд хүргүүлэхээр шийдвэрлэв.

6.10. “Гамшгийн эрсдэлийг бууруулах Үндэсний зөвлөлийн ажиллах журам”-ын төслийг батлуулах тухай хэлэлцээд дэмжив.

6.11. “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ын төслийг батлуулах тухай хэлэлцээд Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр Шадар сайдын ажлын албанд хүргүүлэхээр шийдвэрлэв.

6.12. “Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын хувцас хэрэглээний хангалт олгох, бүртгэл хөтлөх заавар”-ын төслийг батлуулах тухай хэлэлцээд дэмжив.

6.13. ОБЕГ-ын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд эхний хагас жилийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгийн тухай хэлэлцээд 90,2 хувийн үнэлгээтэй батлав.

---oOo---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2020.08.17-ны өдрийн 07 дугаар хуралдааны шийдвэрээс:

7.1. Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газарт иж бүрэн шалгалт зохион байгуулсан дүнгийн тухай хэлэлцээд дүнг 73,2 хувийн үнэлгээтэй батлав.

7.2. Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газарт иж бүрэн шалгалт зохион байгуулсан дүнгийн тухай хэлэлцээд дүнг 85,7 хувийн үнэлгээтэй батлав.

---oOo---